



НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/259

Улаанбаатар хот

Улсын үзлэгт бэлтгэх  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 23/15 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/518 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг зохион байгуулагдах болсонтой холбогдуулан тус үзлэгт бэлтгэх зорилго бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Үзлэгийн бэлтгэл зохион байгуулалтыг сайтар хангаж, төлөвлөгөө гарган батлуулж, төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг ажлын хэсгийн гишүүдэд үүрэгжүүлэн, хяналт тавьж, холбогдох байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, идэвх санаачлагатай ажиллахыг ажлын хэсэг /Д.Төмөрбаатар/-т үүрэг болгосугай.

3. Улсын үзлэгт бэлтгэхэд шаардагдах зардлын тооцоог гарган танилцуулж, шийдвэрлүүлэн ажиллахыг Ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.

4. Үзлэг угтаж хийсэн ажлын талаар танилцуулга бэлтгэн, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллахыг Ажлын хэсэг /Д.Төмөрбаатар/-т, амжилттай дүн үзүүлсэн тохиолдолд холбогдох албан хаагчдыг шагнаж урамшуулахыг Захиргаа санхүүгийн хэлтэс /Х.Жаргалсайхан/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ




Ш.ҮНЭНБАТ

Тушаал-2019

115050000825

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
газрын даргын 2019 оны 07 дүгээр сарын  
18-ны өдрийн тушаалын хавсралт



### Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Төмөрбаатар Орлогч дарга

Гишүүд:

Н.Золжаргал Захиргаа санхүүгийн хэлтсийн ахлах, хүний нөөцийн мэргэжилтэн

Н.Болормаа Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн

С.Ариунжаргал Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ж.Сувданзаяа Өмчийн хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн

Т.Оюунтуул Захиргаа санхүүгийн хэлтсийн нягтлан бодогч

Ц.Цолмон Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн

П.Түвшинжаргал Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Оюун-Эрдэнэ Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн

Э.Дөлгөөн Захиргаа санхүүгийн хэлтсийн бичиг хэргийн ажилтан

Зөвлөлийн нарийн бичиг:

Т.Азжаргал Захиргаа санхүүгийн хэлтсийн архивын ажилтан